



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/255

Улаанбаатар хот

**Заавар батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл бүхий тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлогч, тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөгдөх "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед гарч болзошгүй ослын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ зааврыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа Б.Баянмөнх)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ  БАРИУНБУЯН





**ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН  
ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ОСЛЫН ХАРИУ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх олон улс, улс, орон нутгийн чанартай авто зам, талбайд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэхтэй холбогдсон харилцааг энэхүү заавраар зохицуулна.

1.2. Энэ зааврыг хэрэгжүүлэхдээ Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Автотээврийн тухай хууль, Автозамын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох стандарт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг удирдлага болгоно.

1.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон түүний үндсэн түүхий эдийг тээвэрлэх ажиллагааг улс хоорондын тээвэрлэлт, хот хоорондын тээвэрлэлт, орон нутгийн тээвэрлэлт, ажлын байран дахь тэсрэх материалын тээвэрлэлт гэж ангилна.

1.4. Ажлын байран дахь тэсрэх материалын тээвэрлэлтийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу гүйцэтгэнэ.

**ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ**

2.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед гарч болзошгүй ослын хариу арга хэмжээний төлөвлөгөө нь үндсэн төлөвлөлт, Тээвэр зохион байгуулалт, хавсралт хэсгээс бүрдэнэ.

2.2. Үндсэн төлөвлөлт хэсэгт дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

- худалдан авагч аж ахуйн нэгжийн нэр;
- тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжийн нэр;
- тээвэрлэлт хийх хугацаа;
- тээвэрлэлт хийх үндсэн чиглэл (ачаа ачсан эхний цэгээс ачаа шилжүүлэх ачих цэг түүнээс худалдан авагчийн баталгаат агуулах хүртэл)
- төлөвлөгөөний зорилго;
- ачааны нэршил, хэмжээ;
- хамрах хүрээ;
- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгж, компанийн хор, аюулын лавлах мэдээллийг (ХАЛМ) нарийвчлан тусгах

2.3. Тээвэр зохион байгуулалт хэсэгт дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

- Монгол Улсын Замын-Үүд боомтын аюултай ачаа "Шилжүүлэн ачих анги"-ийн талбай хүртэл улс хооронд аюултай ачаа тээвэрлэх "F" зөвшөөрөлтэй гадаад болон дотоодын аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хүлээн авагч	Автомашин улсын, арлын дугаар	Чиргүүлийн улсын, арлын дугаар	Барааны код	Тээвэрлэх хэмжээ /тонн/
1	..... ХХК	Е.....	Е.....		
2					

- Монгол Улсын Замын-Үүд боомтын аюултай ачаа "Шилжүүлэн ачих анги"-ийн талбайгаас худалдан авагч аж ахуйн нэгжийн баталгаат агуулах хүртэл тээвэрлэлт хийх тээврийн хэрэгслийн мэдээлэл:

№	Жолоочийн овог нэр	Холбогдох дугаар	Байгууллага	Тээврийн хэрэгслийн дугаар	Чиргүүлийн дугаар	Барааны код	Тээвэр-лэх хэмжээ /тонн/
1		99.....	..... ХХК	0000УНТ	0000ГЧ		
2							

- Шаардлагатай үед ашиглагдах нөөц тээврийн хэрэгслийн мэдээлэл:

№	Жолоочийн овог нэр	Холбогдох дугаар	Байгууллага	Тээврийн хэрэгслийн дугаар	Чиргүүлийн дугаар	Барааны код	Тээвэр-лэх хэмжээ /тонн/
1		99.....	..... ХХК	0000УНТ	0000ГЧ		
2							

- аюултай ачаа тээвэрлэх замын үндсэн болон нөөц бүдүүвч зураглал (Ачаа ачих газар, хооллох газар, хатуу хучилттай зам, түлш цэнэглэх газар, холбоо барих газар, хоноглох газар, ачаа буулгах газар зэргийг дэлгэрэнгүй тусгах мөн тус зураглал нь Монгол Улсын хилээр нэвтрэхээс эхлээд ачааг буулгах аж ахуй нэгж, байгууллага хүртэл тасралтгүй тусгасан байх) энэхүү заалтыг хангахгүй бол төлөвлөгөөг батлахгүй үндэслэл болно.

- болзошгүй осол аваарын үед ашиглах багаж хэрэгслийн жагсаалт;
- болзошгүй осол аваарын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний дараалал, бүдүүвч, схем; (зам тээврийн осол, машин унасан, гал гарсан, байгалийн гамшиг тохиолдох г.м)

2.4. Төлөвлөгөөний хавсралт хэсэгт дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

- болзошгүй осол аваарын үед мэдээлэх албан тушаалтны утасны дугаарын жагсаалт;

- тээвэрлэлтийн үед дамжин өнгөрөх аймаг, сум, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, бүлэг, цагдаа, эрүүл мэндийн байгууллагын тусгай дугаарын жагсаалт;

- Тээвэрлэлтийн үед дамжин өнгөрөх зам дагуу байрлах өргөх болон буулгах хүнд машин механизмын судалгаа;

- аюултай ачаа тээвэрлэх жолоочийн мэдээлэл; (жолооны үнэмлэх, ажил байдлын тодорхойлолт, тэсэрч дэлбэрэх бодистой харьцах эрхийн үнэмлэхийн хуулбар, жолоочийн гэрийн хаяг, утасны дугаар)

- аюултай ачаа тээвэрлэхэд дагалдан явах ажилтан байгаа бол түүний ерөнхий мэдээлэл; (ажил байдлын тодорхойлолт, тэсэрч дэлбэрэх бодистой харьцах эрхийн үнэмлэхийн хуулбар, гэрийн хаяг, утасны дугаар)

- жолоочийн хариуцлагын даатгал;

- тээврийн хэрэгслийн даатгал;

- тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;

- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслүүдэд гаргасан Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, түүнтэй танилцсан баримт бичиг; (тээврийн хэрэгслийн жолооч болон ачаа дагалдах ажилтан)

- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, түүнтэй танилцсан баримт бичиг, тээврийн хэрэгслийн жолооч болон ачаа дагалдах ажилтан;
- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдан авагч аж, ахуйн нэгж байгууллагын танилцуулга;
- аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- тусгай зөвшөөрлийн хуулбар;
- тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдан авах гэрээний хуулбар; /монгол хэлээр/
- худалдан авагч аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн эзэмшлийн аюултай ачаа тээвэрлэх хуульд заасан зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгсэлгүйн улмаас бусад аж ахуйн нэгж байгууллагатай аюултай ачааны тээврийг гэрээгээр гүйцэтгэж байгаа бол тухайн гадаад болон дотоодын аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний хуулбар (монгол хэлээр)
- аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- тусгай зөвшөөрлийн хуулбар
- гадаад болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагатай аюултай ачааны тээврийг гүйцэтгүүлэх гэрээний хуулбар /монгол хэлээр/
- тээвэрлэлт хийх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн танилцуулга /Олон улсын нэршил, ижил төстэй нэршил, молекул масс, химийн томъёо г.м/
- хор аюулын талаарх мэдээлэл
- тээвэрлэлт хийх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслүүдийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- тээврийн хэрэгслүүдийг аюултай ачаа тээвэрлэхээр бэлтгэсэн байдал гэрэл зураг, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслүүдийг газар дээр нь шалгаж болно.

### ГУРАВ. ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Төлөвлөгөөнд тээвэрлэх тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн шинж чанарт тохируулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байна.

3.2. Болзошгүй осол аваарын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангах талаар нарийвчлан тусгах;

3.3. Төлөвлөгөөнд тусгасан баримт бичгийн үнэн зөв эсэхийг төлөвлөгөө боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

### ДӨРӨВ. ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ

4.1. Зааврын дагуу боловсруулсан төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллагад төлөвлөгөө батлуулах албан бичгийн /хүсэлт/ хамт хүлээн авна.

4.2. Төлөвлөгөөг аюултай ачаа тээвэрлэх бүрд ачааны шинж чанар, гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тохируулан боловсруулан батлуулна.

4.3. Төлөвлөгөөг аюултай ачааг тээвэрлэж эхлэхээс өмнө боловсруулж батлуулна.

4.4. Төлөвлөгөөг батлахад шаардагдах нэмэлт мэдээлэл, баримт бичгийг төлөвлөгөө боловсруулсан аж ахуй нэгж, байгууллага үнэн зөв, заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

4.5. Төлөвлөгөөг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж хувийг аж ахуй нэгж, байгууллага, төлөвлөгөө баталсан Онцгой байдлын байгууллагад тус тус хадгална.

4.6. Онцгой байдлын байгууллагад ирүүлсэн хүсэлт, төлөвлөгөөг чиглэл хариуцсан байцаагч хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 5 хоногт хянаж, эрх бүхий албан тушаалтнаар батлуулах бөгөөд нэмэлт мэдээлэл авах зорилгоор төлөвлөгөөг 5 хоног сунгах, төлөвлөгөө шаардлага хангахгүй тохиолдолд буцааж болно.

4.7. Буцаагдсан төлөвлөгөөг дахин хүлээн авсан бол 4.6-д заасан хугацаанд шийдвэрлэнэ.

4.8. Батлагдсан төлөвлөгөөний дагуу аюултай ачаа тээвэрлэх үед дагаж мөрдөх үүргийг төлөвлөгөө батлуулсан аж ахуйн нэгж, байгууллага хүлээнэ.

---oOo---

ТАВ. ХАВСРАЛТ

5.1. Төлөвлөгөөг дараах байдлаар батлуулна. (төлөвлөгөөний нүүрэнд байна)

*/Жишээ/*

БАТЛАВ  
..... ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ  
Д.БОЛД  
он, сар, өдөр

БАТЛАВ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА, ХУРАНДАА  
Д.БОЛД

он, сар, өдөр

5.2. Төлөвлөгөөний нэршил дараах загвартай байна.

БНХАУ-ЫН ЭРЭЭН БООМТООС МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН-ҮҮД БООМТООР ДАМЖУУЛАН ..... АЙМГИЙН ..... СУМД  
БАЙРЛАХ "....." ХХК-ИЙН АГУУЛАХ ХҮРТЭЛ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН  
ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ОСЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*/төлөвлөгөө хүчинтэй байх хугацаа нэг сараас ихгүй байна/  
20... оны ... дугаар сарын .... өдрөөс ...дугаар сарын ... өдрийг хүртэл*

Улаанбаатар хот  
2024 он

5.3. Төлөвлөгөөг дараах байдлаар хянуулна. (төлөвлөгөөний сүүлд байна)

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН:  
ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
ЦОЛ Д.БОЛД

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

1. ....  
ХУДАЛДАН АВАЛТ ХИЙЖ БАЙГАА АНБ-ЫН ТӨЛӨӨЛӨЛ  
(УТАСНЫ ДУГААР)
2. ....  
ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙЖ БАЙГАА АНБ-ЫН ТӨЛӨӨЛӨЛ  
(УТАСНЫ ДУГААР)